

**МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ**

№ 16/3

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2016 оны 7 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд нийт 2 удаа хуралдсан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал хурлыг удирдан явуулав.

2016 оны 7 дугаар сарын 7-ны өдөр МБЗ нь Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулсан макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, мөнгөний бодлогын төлөвийг өөрчлөх хэд хэдэн хувилбар, тэдгээрийн үр дагаврын талаарх асуудлуудыг авч хэлэлцэв.

Америкийн Нэгдсэн Улсын эдийн засгийн өсөлт өмнөх улирлынхаа түвшинд хадгалагдсан бол Хятад, Евро бүсийн эдийн засгийн өсөлт бага зэрэг саарлаа. Хятадын эдийн засгийн өсөлт саарахад аж үйлдвэрийн салбарын бууралт голчлон нөлөөлжээ. Гадаад эдийн засгийн орчны төлөв төдийлөн сайжирахгүй буюу гадаад эрэлтийн өсөлтийн эрч сулрах, худалдааны нөхцөл муудах, экспортын түүхий эдүүдийн үнийн тодорхой бус байдал хэвээр үргэлжлэх, гадаад хүү өсөхөөр байгаа нь дотоод эдийн засагт эерэг нөлөө үзүүлж чадахааргүй байна.

Эдийн засаг 2016 оны 1 дүгээр улиралд уул уурхайн салбарын голлох нөлөөгөөр 3.1 хувиар өссөн бол уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл 4 улирал дараалан буурлаа. Уул уурхайн бус салбарын өсөлтөд худалдаа, боловсруулах салбар сөрөг нөлөө үзүүлсэн бол барилгын салбар тэр дундаа орон сууцны барилга, хөдөө аж ахуйн салбар эерэг нөлөө үзүүлжээ. Харин нийт эрэлт талаас нь авч үзвэл засгийн газрын хэрэглээ болон экспорт өсч, импортын хэрэглээ буурсан нь эдийн засгийн өсөлтийг тэтгэсэн бол хөрөнгө оруулалт, хувийн хэрэглээ агшсан нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Сүүлийн 4 улирал дараалан агшаад байсан мөнгөний нийлүүлэлт тайлант улиралд өсөлттэй гарсан. Үүнд актив талаас хадгаламжийн байгууллагын гадаад цэвэр актив, эх үүсвэр талаас иргэдийн төгрөгийн хадгаламж тус тус өссөн нь нөлөөлөв. Инфляци нам тогтвортой түвшинд хадгалагдаж байгаа ч суурь төсөөллөөр 2016 оны эцэст 4.7%-д хүрч, түүнээс хойш нэмэгдэх төлөвтэй байна.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс алдагдалтай хэвээр байгаа хэдий ч түүнийг нөхөх хэмжээний хөрөнгө санхүүгийн дансны ашиг бий болохоор байгаа учир төлбөрийн тэнцэл ашигтай гарахаар хүлээгдэж байна.

МБГ-аас эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан хийсэн шинжилгээ, төсөөлөл дээр үндэслэн бодлогын саналыг танилцуулсан. Суурь төсөөллөөр инфляци Оюу толгойн хөрөнгө оруулалт болон суурь үеийн нөлөөгөөр 2016 оны 4 дүгээр улирлаас эрчимжиж, 2017 оны төгсгөлд зорилтот түвшнээс өндөр болох эрсдэлтэй гэж үзэн бодлогын хүүг өөрчлөхгүй 10.5 хувьд хэвээр хадгалах саналыг дэвшүүлсэн. Мөн мөнгөний бодлогыг сулруулах орон зай ирэх улирлуудад хумигдаж, харин өсгөх шаардлага бий болж байгааг УИХ, Засгийн газар болон олон нийтэд тайлбарлаж, таниулах ажлыг одооноос олон нийттэй харьцах бодлогоороо дамжуулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Хурлын төгсгөлд МБЗ-ийн ажиллах журмын дагуу Монголбанкны Ерөнхийлөгч мөнгөний бодлогын саналыг шүүмжлэх болон хамгаалах багийг тус тус томилсон болно.

МБЗ-ийн 2016 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хурлаар МБЗ-ийн гишүүд Бодлогын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнүүлээ.

Мөнгөний бодлогын хүүг хэвээр үлдээхийг шүүмжилж байсан гишүүд эдийн засгийн өсөлт удааширсан, банкны зээлийн өсөлт саарсан, ажилгүйдэл өндөр байгаа үед бодлогын хүүг бага зэрэг бууруулах нь зүйтэй. Инфляци оны эцэст өсөх төсөөлөл байгаа тул бодлогын хүүг ч мөн нэмэгдүүлэх хүлээлт байна. Тиймээс энэ удаад бодлогын хүүг бага зэрэг бууруулаад байдлыг харах хэрэгтэй. Мөн төсвийн тодотгол хийснээр хэд хэдэн зардлууд танагдаж төсвийн хумих бодлого хэрэгжиж болзошгүй байна. Иймд төсөв мөнгөний бодлогын уялдааг ханган төсөв тал дээр хумьж байхад мөнгөний бодлогоо зөөлрүүлэх хэрэгтэй гэсэн саналыг гаргав.

Харин МБГ-аас гаргасан саналыг дэмжсэн гишүүд шинэ засгийн газар байгуулагдаж байгаатай холбоотой тодорхой бус байдал их байгаа үед бодлогын хүүг буулгах нь хэтэрхий эрсдэлтэй. Цаашлаад бодлогын хүүг бууруулснаар валютын ханшийн дарамт нэмэгдэж, улмаар ханш сулрах нь хувийн хэвшлийн гадаад өрийн ачааллыг нэмэгдүүлэх аюултай. Өмнөх жилүүдэд төсвийн орлогын өсөлтийг дагаж төсвийн зардал нэмэгдэж байсан бол 2016 онд төсвийн орлого буурсан ч төсвийн зардал өссөн байна. Энэ нь засгийн газрын өр, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болж улсын төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.

Мөн 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар макро эдийн засгийн нөхцөл байдал, банкны салбарын эрсдэлүүд өсч, эерэг өөрчлөлтүүд гараагүй байна. Өөрөөр хэлбэл 5 дугаар сарын 5-нд гаргасан бодлогын хүүг 1.5 нэгж хувиар бууруулсан мөнгөний бодлогын шийдвэрээс хойш эерэг үр дүн гарсангүй. Харин ч сөрөг үр дагавар гарсан байхад хүүг бууруулах нь эрсдэлтэй. Иймд санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж дүгнэв. Цаашлаад бодлогын хүүг нэмэгдүүлэх нь 2016 оны төгсгөлд өсөх төсөөлөл бүхий инфляцийн дарамтыг хязгаарлах эерэг үр дагавартай ч тодорхой бус байдал хэтэрхий их байна. Иймд 6 дугаар сарын статистик мэдээллүүд гарсаны дараа макро эдийн засгийн төсөөллүүдээ шинэчилж бодлогын хүүг өсгөх талаар ярих нь зүйтэй тул Бодлогын хүүг хэвээр үлдээх саналыг дэмжиж байв.

МБГ-ын саналыг шүүмжлэгч, дэмжигч гишүүд мөнгөний бодлого төсвийн бодлоготой уялдах хэрэгтэй. Шинэ засгийн газар хүүг бууруулах бодлого баримтлана гэж байгаа ч засгийн газрын зорьж буй алхам одоохондоо томъёологдоогүй байгаа нь тодорхой бус байдлыг үүсгэж байна. Иймд бодлогын хүүг хэвээр үлдээж байдлыг харах нь оновчтой гэсэн санал дээр нэгдэв.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогын хүүг хэвээр үлдээх саналыг тал бүрээс нь авч үзэн, өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэний эцэст Мөнгөний бодлогын төлөвийг хэвээр үлдээх томъёоллоор санал хураахад МБЗ-ийн гишүүдийн 100%-ийн саналаар Бодлогын хүүг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.

Хурлын төгсгөлд Мөнгөний бодлогын мэдэгдлийн бүтцийн талаар хэлэлцэв. Мөнгөний бодлогын мэдэгдэлд “Бодлогын энэ шийдвэр нь мөнгөний нийлүүлэлтийг хувийн хэвшлийн зээлээр нэмэгдүүлэх, бодит секторын идэвхжилийг дэмжих боломжийг хадгална. Гадаад цэвэр активыг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах нь хувийн хэвшил агших, ажилгүйдэл одоогийн 11.6%-иас илүү хурдацтай өсөх, санхүүгийн эх үүсвэр хомсдох эрсдэлийг бууруулахад дэмжлэг болно” гэсэн өгүүлбэрүүдийг тусгах нь зүйтэй гэснээр МБЗ-ийн хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2016 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг хэвээр үлдээж, 10.5 хувьд хадгалах шийдвэр гаргалаа. Энэхүү мөнгөний бодлогын шийдвэрийг 2016 оны 7 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.